



**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар A/148

Улаанбаатар хот

**Төрийн захиргааны албан хаагчийн  
ёс зүйн дэд хороо байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улс ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд улиралд нэг, нарийн бичгийн даргад сар бүр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшуулалт олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Р.Дулмаа)-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дэд хорооны гишүүдийн хурлын бэлтгэл, зохион байгуулалтыг чанарын өндөр түвшинд хийж, хурлаас гарсан шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх, шийдвэрийг байгууллагын албан хаагч нарт тухай бүр мэдээлж ажиллахыг ёс зүйн дэд хороо (Н.Мэндсайхан)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөвлөлийг байгуулах тухай” А/58 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, удирдлагын хэлтэс (У.Бат-Очир)-д даалгасугай.



1550001414

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
даргын 2024 оны 10 дугаар сарын 10 -ны  
өдрийн 10 дугаар тушаалын хавсралт



ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН  
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Ёс зүйн дэд  
хорооны дарга:

Н.Мэндсайхан /Халдварт бус өвчний хяналт,  
сэргийлэлт, эрт илрүүлэгийн асуудал хариуцсан  
ахлах мэргэжилтэн/

Гишүүд:

Ц.Сонгиносүрэн /Статистик мэдээлэл хариуцсан  
ахлах мэргэжилтэн/

Б.Баатарсүх /Зонхилон тохиолдох халдварт  
өвчний тандалт, сэргийлэлт, хариуцсан ахлах  
мэргэжилтэн/

Б.Булганзаяа /Хөрөнгө оруулалтын төлөвлөлт,  
хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн/

М.Галбадрах /Орчны эрүүл ахуйн хяналтын улсын  
байцаагч/

Д.Оюун-Эрдэнэ /Сувилахуй, хөнгөвчлөхийн  
тусламж үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн/

Нарийн  
бичгийн дарга:

Э.Энхжин /Албан хэргийн эрхлэгч/